



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 09 сарын 19 өдөр

Дугаар СХШ-2025/21/-ТШЗ

Сүхбаатар сум

**Сайхан сумын Засаг даргын тамгын
газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
Хяналт шалгалтын дүн**

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн СХШ-2025/21/-ТШЗ дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Сайхан сумын Засаг даргын Тамгын газрын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дотоод аудитор, СХШУБ Ц.Уртнасан 2025 оны 09 дугаар сарын 01-ний өдрөөс ажлын 15 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Сайхан сумын Засаг даргын Тамгын газрын (цаашид Сайхан сумын ЗДТГ гэх)-ын 2023 оны 04 сарын 01 өдрөөс 2025 оны 03 сарын 31 өдөр хүртэлх хугацааны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Сайхан сумын ЗДТГ нь улсын бүртгэлийн 9055185 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130955001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100130955408 дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5. Сайхан сумын Төсвийн орлого, зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ЗДТГ-ын дарга Б.Мөнхцэцэг, 2-р гарын үсгийг ахлах нягтлан бодогч Г.Ариунаа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Сайхан сумын ЗДТГ нь улс төрийн албан тушаалтан 5, төрийн захиргааны албан хаагч 12, төрийн үйлчилгээний бусад албан хаагч 4, гэрээт ажилтан 11 нийт 32 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлт, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлж ажилласан байна.

2.1.2 Сайхан сумын ЗДТГ-ын төсвийн хөрөнгийг зарцуулах захиргааны шийдвэр гаргахдаа Захиргааны актад утга, агуулгын алдаагүй бодит нөхцөл байдлыг тогтоосон эрх зүйн үндэслэл хэсэгт нарийвчилсан зохицуулалтай хуулийн заалт, болон хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актын зүйл заалтыг ашиглахгүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

2.1.3 Сайхан сумын ЗДТГ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

Сайхан сумын ИТХ-ын тогтоолоор тус байгууллагын төсвийг санхүүжүүлэхээр 2023 онд 2,432,788.6 мянган төгрөг, 2024 онд 2,916,894.4 мянган төгрөг, 2025 онд 2,710,417.2 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

№	Огноо	ИТХ-ын тогтоолын огноо, дугаар	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү /Үлдэгдэл	Хувь
1	2023	2023 оны 20 тогтоол	2,432,788.6	1,680,405.3	752,383.3	69.1
2	2024	2024 оны 19 тогтоол	2,916,894.4	2,346,304.5	570,589.9	80.4
3	2025	2024 оны 15 тогтоол	2,710,417.2	532,081.6		
	2025 -1 улирал		926,853.8	532,081.6	204,772.2	57.4

2023 онтой харьцуулахад 2024 онд батлагдсан төсөвт орсон өөрчлөлт:

- Засгийн газрын 2024 оны 82 тогтоолын дагуу цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 637,951.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 87,749.9 мянган төгрөгөөр,
- Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгосон мөнгөн урамшуулал зардал 30,702.0 мянган төгрөгөөр,
- Сайхан сумын Хот тохижилтийн газрын зардлыг сумын ЗДТГ-ын төсөв дээр нэмж оруулснаас шалтгаалж байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 71,292.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 41,058.9 мянган төгрөгөөр, норматив зардал 6,756.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 36,921.3 мянган төгрөгөөр тус тус өссөн дүнтэй батлагдсан байна.

2024 онтой харьцуулахад 2025 онд батлагдсан төсөвт орсон өөрчлөлт:

- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2025 онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 219,905.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн,
- Бүтцийн өөрчлөлтөөр гарсан улс төрийн албан хаагчид олгох тэтгэмж 12,870.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн,
- Хөрөнгө оруулалтын зардал 663,901.6 мянган төгрөгөөр буурч тус тус батлагдсан байна.

2.2.2 Төсвийн зардлын гүйцэтгэл:

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2023 он		2024 он		2025 оны 1 улирал	
		Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,432,788.6	1,680,405.3	2,916,894.4	2,346,304.5	926,853.8	532,081.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,538,392.0	1,325,218.1	1,954,992.8	1,797,131.8	926,853.8	532,081.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,536,075.8	1,324,488.1	1,922,290.8	1,766,329.7	722,408.8	532,081.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,217.1	528,114.1	1,244,168.6	1,132,212.2	304,501.2	220,311.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,738.5	65,387.6	165,488.4	147,705.1	37,569.2	20,782.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,319.4	59,969.9	138,611.9	130,395.7	40,644.8	20,426.2
2104	Хангамж, бараа материалын зардал	57,005.8	39,425.5	98,064.7	96,139.6	15,452.4	10,914.9
2105	Норматив зардал	607.5	100.0	7,363.6	7,363.4	584.3	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,165.7	60,394.9	61,800.5	61,378.8	34,600.0	7,955.7
2107	Томиллолт, зочны зардал	4,765.5	4,765.5	7,416.8	7,413.0	2,975.6	1,880.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,743.7	6,931.0	46,665.0	33,085.5	232,316.2	219,280.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	641,512.6	559,399.6	152,711.3	150,636.5	53,765.1	30,529.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,316.2	730.0	32,702.0	30,802.1	14,445.0	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,316.2	730.0	32,702.0	30,802.1	14,445.0	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	894,396.6	355,187.2	981,901.6	549,172.7	190,000.0	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,432,788.6	1,680,405.3	2,916,894.4	2,346,304.5	926,853.8	604,391.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	997,913.5	1,680,405.3	2,916,894.4	2,346,304.5	926,853.8	604,391.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,434,875.1	0.0				
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,434,875.1	0.0				

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2023 онд 1,680,405.3 мянган төгрөг буюу 69.1 хувь, 2024 онд 2,346,304.5 мянган төгрөг буюу 80.4 хувь, 2025 оны 1 улирлын байдлаар 532,081.6 мянган төгрөг буюу 57.4 хувиар тайлагнасан байна.

2023 онд нийт 752,383.3 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь:

- 2 орон тоо дутуу ажилласнаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 78,103.1 мянган ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 12,350.9 мянган төгрөг,
- Усны тоолуур тавиулснаар зардал нь багассанаар тогтмол зардал 7,349.5 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардал 17,580.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 10,770.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 82,113.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2,812.7 мянган төгрөг, хөрөнгийн оруулалтын зардал 539,209.4 мянган төгрөг, бусад зардлаас 2,093.5 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

2024 онд нийт 570,589.9 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь:

- 2 орон тоо дутуу ажилласнаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 111,956.4 мянган ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 17,783.3 мянган төгрөгөөр,
- Тогтмол зардал 8,216.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 1,925.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 13,579.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 2,074.8 мянган төгрөг, хөрөнгийн оруулалтын зардал 412,728.9 мянган төгрөг, бусад зардлаас 2,325.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

2025 оны 1 улирлын байдлаар нийт 204,772.2 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь:

- 2 орон тоо дутуу ажилласнаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 84,189.3 мянган ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 16,786.4 мянган төгрөг,
- Тогтмол зардал 20,218.6 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 4,537.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 26,644.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 13,035.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 23,235.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 14,445.0 мянган төгрөг, бусад зардлаас 1,680.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөж байх шаардлагатай байна.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд:

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

	2023 он	2024 он	2025 оны 1 улирал
Өмнөх оны үлдэгдэл	0.0	0.0	0.0
Орлого	22,469.7	34,538.6	9,611.5
Гүйцэтгэл	22,469.7	34,538.6	5,000.0
Эцсийн үлдэгдэл	0.0	0.0	4,611.5

Нэмэлт санхүүжилтийн дансанд:

- 2023 онд дээд шатны удирдлагаас 22,469.7 мянган төгрөг /ахмадын хорооны зардал, гэр бүл тэмцээний зардал, тамирчин хамт олон, алтан намар арга хэмжээ, гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны зардал, мал тооллого, замд гарья аян, шатахууны зардал, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зардал, нүтс зардал/, -ийн орлого орж, зардлыг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.
- 2024 онд дээд шатны удирдлагаас 34,538.6 мянган төгрөг /үзэсгэлэн худалдааны шатахуун, мал тооллого, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зардал/ -ийн орлого орж, зардлыг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.
- 2025 оны 1 улиралд дээд шатны удирдлагаас 9,611.5 мянган төгрөг /фондны өвсний мөнгө/ -ийн орлого орсон ба үүнээс 5,000.0 мянган төгрөгийг зарцуулж 4,611.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны Б/28 дугаар, 2024 оны Б/50 дугаар, 2025 оны Б/02 дугаар захирамжаар сумын Засаг даргын цалинг, сумын Засаг дарын 2023 оны Б/04 дугаар, 2024 оны Б/02 дугаар, 2025 оны Б/01 дугаар захирамжаар сумын орлогч дарга, ЗДТГ-ын дарга, багийн дарга нарын цалинг, ЗДТГ-ын ажилтан албан хаагчдын цалинг тамгын газрын даргын 2023 оны Б/01 дугаар, 2024 оны Б/01 дугаар, 2025 оны Б/01 дугаар тушаалаар тус тус шинэчлэн баталсан байна.

Сумын ЗДТГ-ын бүтэц орон тоо баталсан тушаалд Төрийн үйлчилгээний туслах /дэд бүтэц, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, түр хамгаалах байны нийгмийн ажилтан, хэвлэл мэдээллийн ажилтан, газрын даамал, жолооч, үйлчлэгч, жижүүр/ гэсэн албан тушаалын ажил үүргийг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлэхээр баталсан боловч, цалин шинэчлэн тогтоох тушаалд албан тушаалын ангиллыг ТҮ албан хаагчаар баталж тус ангиллын цалингийн

сүлжээгээр цалинжуулж орон нутгийн нэмэгдэл болон төрийн алба хаасан нэмэгдлийг олгосон байна.

2.4. Орон нутгийн хөрөнгө оруулалт түүний хэрэгжилт үр дүн

Сайхан сумын ИТХ-ын 2023 оны 20 дүгээр тогтоолоор батлагдсан 2023 оны төсөвт тусгагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар Шинэ хөтөл суурьшлын бүс рүү шилэн кабел татах 16,000.0 мянган төгрөгийн, Орон сууцны хорооллын ТК11 худаг солих, инженерийн шугам солих 19,995.0 мянган төгрөгийн, Нийтийн эзэмшлийн төв талбайг засварлах ажил 59,335.6 мянган төгрөгийн, Спорт залны засварын ажил 5,000.0 мянган төгрөгийн, Цахилгааны шугам татах ажил 14,968.9 мянган төгрөгийн, Хогийн цэгийг түрж далан бий болгох 20,000.0 мянган төгрөгийн, Номгон тосгоны 12 айлын дээврийн засвар 40,000.0 мянган төгрөгийн, Төв цэвэрлэх байгууламжийн хий насос шинээр байгуулах 34,980.0 мянган төгрөгийн, Дөмбөн хорооллын хүүхдийн талбай шинээр хийх ажил 59,440.2 мянган төгрөгийн 9 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Сайхан сумын ИТХ-ын 2024 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 оны төсөвт тусгагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 943,901.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ батлагдсанаас бүрэн хэрэгжсэн Төв талбайн тохижилт 260,000.0 мянган төгрөгийн, Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх /Хөтөл, Номгон/ 242,241.7 мянган төгрөгийн, Ус сувгийн дэнжийн тоггүй айл өрхүүдэд цахилгааны шугам татах ажил 71,659.9 мянган төгрөгийн, Түр хамгаалах байрны тохижилт 30,000.0 мянган төгрөгийн, Иж бүрэн тайз худалдан авах 70,000.0 мянган төгрөгийн арга хэмжээ хэрэгжсэн ба 1 төсөл арга хэмжээ, огт хэрэгжээгүй байна.

Сайхан сумын ИТХ-ын 2024 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан 2025 оны төсөвт тусгагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 280,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ батлагдаж Зам сайжруулах /Жимстэй хороолол, ЗДТГ-ын ард/ 270,000.0 мянган төгрөгийн, Номгон тосгоны камержуулалт 10,000.0 мянган төгрөгийн ажлууд бүрэн хэрэгжсэн байна.

2.5. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт

Хүснэгт 4.

(мянган төгрөгөөр)

№		2023 он	2024 он	2025 оны 1 улирал
1	Батлагдсан төсөв	120,500.0	140,859.5	45,750.6
2	Гүйцэтгэл	89,953.4	140,606.5	28,529.3
3	Зөрүү	30,546.6	253.0	17,221.3
4	Гүйцэтгэлийн хувь	74.6%	99.8%	62.3%

Засаг даргын нөөц хөрөнгийн зардалд 2023 онд 120,500.0 мянган төгрөг баталж 2024 онд 140,859.5 мянган төгрөг баталж 2025 оны 1 улирлаар 45,750.6 мянган төгрөг баталсан байна. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулах журмын 21.1, 2.1.2-т заасан хохирлыг эхний ээлжид санхүүжүүлэхэд нийт батлагдсан хөрөнгийн 30 хувиас доошгүйг зарцуулах ба сарын хуваариас тооцож нөөцөд бэлэн байршуулсан байх заалтыг зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 2023 онд жилийн эцэст 4.6 хувь буюу 4,137.8 мянган төгрөг, 2024 онд 29.8 хувь буюу 41,900.7 мянган төгрөг нийт 46,038.5 мянган төгрөгөөр нөөц хөрөнгийн үлдэгдлийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгийн зарцуулалтын ажил гүйлгээг анхан шатны баримттай тулган үзэхэд Засаг даргын 2024 оны А/23 захирамжаар засаг даргын нөөц сангаас Сайхан сумын Онцгой байдлын гал унтраах 161 ангид land cruiser 76 авто машины сэлбэг, засварт нийт 8,880.0 мянган төгрөгийг зарцуулсан байна

Сайхан сумын Засаг даргын 2025 оны А/15, А/19, А/22, А/39, А/45, А/46 захирамжаар олгосон зардал нийт 23,942.3 мянган төгрөгийн зарцуулалтын тайлангийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

2.6. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ЗДТГ нь 2023 онд шууд худалдан авах босго үнээс давсан 29,170.0 мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийн шалгаруулаагүй зөрчилд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас албан шаардлага өгсөн байна.

2.7 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтөлсөн байна.

Үндсэн хөрөнгө:

Хүснэгт 5.

(мянган төгрөгөөр)

№	Үндсэн хөрөнгө				
	Огноо	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	2023	1,093,373.6	149,400.2	11,204.2	1,231,569.6
2	2024	1,231,569.6	2,896,257.0	0.0	4,127,826.6
3	2025 - 1 улирал	4,127,826.6	3,630.0	16,367.7	4,115,088.9

2023 онд үндсэн хөрөнгийн орлого:

- ✦ Номгон тосгонд хүлэмжийн газар, Ахмадын газар, Залуучууд хөгжлийн ордны газар, Спорт цогцолборын газар, Номгон тосгонд Биеийн тамир спорт залны газрыг / дансны үнэ 74,459.6 мянган төгрөг/ бусад биет бус хөрөнгө дансанд,
- ✦ Нэг цэгийн үйлчилгээний өргөтгөлд хандиваар засвар хийснийг капиталжуулж бүртгэсэн /дансны үнэ 28,000.0 мянган төгрөг/ ба аймгийн ЗДТГ-аас 4 зөөврийн компьютер /дансны үнэ 8,747.6 мянган төгрөг/ өгснийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансанд,
- ✦ Батлагдсан төсвийн хүрээнд нэг цэгийн үйлчилгээний өргөтгөлд засвар хийснийг капиталжуулж бүртгэсэн /дансны үнэ 15,654.0 мянган төгрөг/ мөн 4 зөөврийн компьютер, 3 принтер, 1 процессор, 1 посс машин, 1 скайнер, 1 цаас устгагч /дансны нийт үнэ 22,538.9 мянган төгрөг/ худалдан авсныг санхүүгийн бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Үндсэн хөрөнгийн зарлага:

- ✦ Сайхан сумын ИТХ-ын 2023 оны 29 дугаар тогтоолоор машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын зардлаас нийт 11,204.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

2024 онд үндсэн хөрөнгийн орлого:

- ✦ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Залуучууд хөгжлийн ордон /дансны үнэ 2,527.3 мянган төгрөг/, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Mitsubishi L200 автомашин /дансны үнэ 187,000.0 мянган төгрөг/, мотоцикл /дансны үнэ 5,136.4 мянган төгрөг/, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гудамжны камер /дансны үнэ 66,159.4 мянган төгрөг/ хүлээн авсныг санхүүгийн бүртгэл тайланд бусад дансанд бүртгэсэн байна.

2025 онд үндсэн хөрөнгийн орлого:

- ✦ Батлагдсан төсвийн хүрээнд 1 таблет /дансны үнэ 3,630.0 мянган төгрөг/ худалдан авсныг санхүүгийн бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Үндсэн хөрөнгийн зарлага:

- ✦ Сайхан сумын ИТХ-ын 2025 оны 13 дугаар тогтоолоор машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын зардлаас нийт 16,367.7 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна

Аудитын явцад санхүүгийн ажилтан албан хаагчидтай хамтарч үндсэн хөрөнгийн тооллого, тулган баталгаажуулалт хийсэн.

Үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтөлсөн боловч удирдах албан тушаалтны хариуцлагагүй, дураараа шийдвэрээс шалтгаалж орон нутгийн өмчийн хөрөнгийг

ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүйгээс дараах зөрчил гарсан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй нийт 46,807.6 мянган төгрөгийн үнэтэй 9 хүлэмжийг Төрийн байгууллага, ТББ, аж ахуй нэгжид 2023 онд олгосон боловч хөрөнгийн бүртгэл хийгээгүй, хөрөнгө хүлээн авсан, өгсөн анхан шатны баримт бүртгэл байхгүй, хариуцах эзэн тодорхойгүй байна. Үүнээс тооллогоор 4 хүлэмж зориулалтын дагуу ашиглаж, 5 хүлэмж огт ашиглаагүй байна.
- Сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 2,680.0 мянган төгрөгийн үнэтэй дроныг сумын Гал унтраах 61 ангид хариуцуулсан боловч сум дундын цагдаагийн хэлтэст дамжуулж ашигласан, хяналт шалгалтын хугацаанд уг дроныг авчираагүй, ЗДТГ-аас хөрөнгө хүлээлгэн өгсөн анхан шатны баримт бүртгэл байхгүй, хариуцах эзэн тодорхойгүй байна.
- Сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 22,123.3 мянган төгрөгийн үнэтэй дайвар хог хаягдал шахагч төхөөрөмжийг Сумын хот тохижуулах газарт хариуцуулсан боловч өнөөдрийг хүртэл ашиглаагүй, айлын хашаанд байрлуулсан байна.
- Тооллогоор ЗДТГ-т хамааралтай, агуулахаар ашигладаг Сайхан сумын 1 багт байрлах газар, 1 автомашины гражийг санхүүгийн бүртгэл тайланд бүртгээгүй байна.

Бараа материал:

Хүснэгт 6.

(мянган төгрөгөөр)

№	Бараа материал				
	Огноо	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	2023	38,993.6	39,135.1	55,724.5	22,404.2
2	2024	22,404.2	539,625.4	547,645.0	14,384.6
3	2025 - 1 улирал	14,384.6	12,285.3	12,175.2	14,494.7

2025 оны 1 улирлын байдлаар 12,285.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 12,175.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь баримтаар нотлогдож байна.

2.8. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 2023 онд 14,215.0 мянган төгрөгийн, 2024 онд 33,328.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж зөрчлийг арилгасан байна.

Хүснэгт 7.

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023 он			2024 он		
	Тоо	Дүн	Биелэлт	Тоо	Дүн	Биелэлт

Акт				1	875.5	100%
Албан шаардлага				2	30,418.0	100%
Зөвлөмж	1	14,215.0	100%	1		100%
Нийт дүн	1	14,215.0		4	33,328.7	

2.9 Дотоод хяналт шалгалтын үр нөлөө

Сайхан сумын Санхүү албаны даргын баталсан төлөвлөгөөний дагуу 2023 онд санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтэд дотоод хяналт хийгдсэн ба 2024, 2025 онд дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сайхан сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, бараа материал, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй зэрэг дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт 1. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулах журмын 21.1, 2.1.2-т заасан хохирлыг эхний ээлжид санхүүжүүлэхэд нийт батлагдсан хөрөнгийн 30 хувиас доошгүйг зарцуулах ба сарын хуваариас тооцож нөөцөд бэлэн байршуулсан байх заалтыг зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 2023 онд жилийн эцэст 4.6 хувь буюу 4,137.8 мянган төгрөг, 2024 онд 29.8 хувь буюу 41,900.7 мянган төгрөг нийт **46,038.5** мянган төгрөгөөр нөөц хөрөнгийн үлдэгдлийг хэтрүүлэн, нөөц хөрөнгийн зориулалтын дагуу үр ашигтай зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.4, 3.5, 4.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, нөөц хөрөнгийн үлдэгдлийг 30 хувиас доошгүй хувийг бэлэн байршуулж байх шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгийн зарцуулалтын ажил гүйлгээг анхан шатны баримттай тулган үзэхэд Засаг даргын 2024 оны А/23 захирамжаар засаг даргын нөөц сангаас Сайхан сумын Онцгой байдлын гал унтраах 161 ангид land cruiser 76 авто машины сэлбэг, засварт нийт 8,880.0 мянган төгрөгийг зарцуулсан байна

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тогтоол Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 3.1 Нөөц хөрөнгийг зарцуулах тухай Засаг даргын шийдвэрийн төсөл нь дор

дурдсан шаардлагыг хангасан байна.; 3.1.2 урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Сайхан сумын Засаг даргын 2025 оны А/15, А/19, А/22, А/39, А/45, А/46 захирамжаар олгосон зардал нийт 23,942.3 мянган төгрөгийн ажил үйлчилгээний тайлан, зургаар баримтжуулаагүй анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тогтоол Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 6.1 дэх "Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ", 6.2 дахь "Нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын тайлан, холбогдох баримтыг ажлын 15 хоногийн дотор гаргуулан авч байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Сумын ЗДТГ-ын бүтэц орон тоо баталсан тушаалд Төрийн үйлчилгээний туслах /дэд бүтэц, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, түр хамгаалах байны нийгмийн ажилтан, хэвлэл мэдээллийн ажилтан, газрын даамал, жолооч, үйлчлэгч, жижүүр/ гэсэн албан тушаалын ажил үүргийг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлэхээр баталсан боловч, цалин шинэчлэн тогтоох тушаалд албан тушаалын ангиллыг ТҮ албан хаагчаар баталж тус ангиллын цалингийн сүлжээгээр цалинжуулж орон нутгийн нэмэгдэл болон төрийн алба хаасан нэмэгдлийг олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно", 57 дугаар зүйлийн 57.17 дахь "Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно". гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах төрийн үйлчилгээний албан хаагчийг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлэхгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 5. Сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй нийт 46,807.6 мянган төгрөгийн үнэтэй 9 хүлэмж, 2,680.0 мянган төгрөгийн үнэтэй дроныг Төрийн байгууллага, ТББ, аж ахуй нэгж ашиглаж байгаа боловч ЗДТГ-аас хөрөнгө хүлээлгэн өгсөн анхан шатны баримт бүртгэл байхгүй, хариуцах эзэн тодорхойгүй, хөрөнгөнд тавих хяналт сул байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.” 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:” 12.2.2 дахь “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;” 12.2.3 дахь “эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед;” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө хүлээлгэн өгөхдөө акт үйлдэх, харилцагч байгууллагатай тухайн хөрөнгийг хүлээн авсан, ашиглалтын гэрээ байгуулах, санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлж байх, ЗДТГ-ын өмч хамгаалах зөвлөл хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалтад хяналт тавьж эвдэрсэн, үрэгдсэн тохиолдолд байгууллагын дотоод журмыг үндэслэн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авахуулах шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6. Тооллогоор ЗДТГ-т хамааралтай, агуулахаар ашигладаг Сайхан сумын 1 багт байрлах газар, 1 автомашины гражийг байгууллагын нэр дээр бүртгүүлж аваагүй, санхүүгийн бүртгэлд тайланд бүртгээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:” 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сайхан сумын ЗДТГ-аас холбогдох байгууллагатай хамтран ажиллах, байгууллагын өмч хамгаалах зөвлөл хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Сайхан сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Сайхан сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **128,348.4** мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн зөрчлийг таслан зогсоох **128,348.4** мянган төгрөгийн 4 албан шаардлага, 2 зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журамд нийцүүлэн ажиллах шаардлагатай байгааг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 01-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДОТООД
АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
Ц.УРТНАСАН



ТАНИЛЦСАН
САЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
О.МОНХЦЭЦЭГ
НЯГТЛАН БОДОГЧ
Г.АРИУНАА

